



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 29 өдөр

Дугаар А/74

Амардалай

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх,
оролцоог хангах орон тооны бус дэд зөвлөл
байгуулах тухай

Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Засгийн газрын 2016 оны 136 дугаар тогтоолоор баталсан "Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх, оролцоог хангах орон тооны бус зөвлөлийн ажиллах журам"-ын 4.3 дахь заалт, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.4, 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд тэгш оролцох эрхийг хангаж, хэрэгжүүлэх, хамгаалахтай холбогдсон үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх, оролцоог хангах орон тооны бус дэд зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга: М.Баярсүх(Засаг дарга)

Дэд дарга: Ц.Билэг-Ариун(Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Б.Энхдэлгэр(ХЭХАХМ мэргэжилтэн)

Гишүүн: Т.Мөнхтуяа(ЭМТ-ийн дарга)

Н.Батцэцэг(НТБ-ын багш)

Н.Сүрьеэрагчаа(Цэцэрлэгийн арга зүйч)

П.Амгаланбаатар(Иргэний төлөөлөл)

Э.Цэрэнханд(Сургуулийн нийгмийн ажилтан)

Г.Сосорбурам(2-р багийн Засаг дарга)

2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах хууль тогтоомжийн талаар төрөөс баримтлах бодлого хөтөлбөр арга хэмжээг орон нутгийн хэмжээнд зохицуулан, төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг хангаж ажиллахыг дэд зөвлөлийн нарийн бичгийн дарга (Б.Энхдэлгэр)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү Захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А/74 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ДАРГА

М.БАЯРСҮХ